



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/203

Арвайхээр

┌ Улсыг үзлэг зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.е, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.5, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах улсын үзлэг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, холбогдох зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус батласугай.

2.Улсын үзлэгт шаардагдах 694200 (Зургаан зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.Улсын үзлэгийг сайтар зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, тайланг нэгтгэн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэг (Б.Сайнжаргал)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100443

Аймгийн Засаг даргын 2020 оны⁰⁵
дугаар сарын 14-ны өдрийн дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



УЛСЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЙМГИЙН
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Сайнжаргал -аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Бүзмаа -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнхбат -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц, төлөвлөлт
хариуцсан мэргэжилтэн

Б.Загдзэсэм -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга: Ц.Энхтуяа -аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр,
халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн
аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

-оОо-

Аймгийн Засаг даргын 2020 оны 05
 дүгээр сарын 14-ны өдрийн 460 дүгээр
 захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д	Сумын нэр	Үзлэгт хамрагдах байгууллагын тоо	Албан томилолт	Шатахууны нийт зардал
1	Арвайхээр	5	0	Дотор явах 120км 40 л*1550= 62000
2	Хархорин	1	6 хүн*1 хоног *18000 төгрөг =108000	Нийт явах 140*2=280км 56 л*1550= 86800
3	Бат-Өлзий	2	6 хүн*2 хоног *26500 төгрөг =318000	Нийт явах 340км 68 л*1550= 105400
4	Бичиг хэргийн зардал			14000
НИЙТ			694200	

-оОо-